

**ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР 2019 ОНД  
АЙМГУУД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛААС ТОВЧ**

**АРХАНГАЙ:**

- Сүүний үхэр, гахай, тахиа, зөгийн аж ахуйнууддаа бүсчлэл тогтоосон.
- Сарлагын шилмэл ангийн 5 толгой бухнаас 300 тун үр авч УСҮТ-ийн генийн санд хадгалсан. Мал аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт амжилтыг ашиглах нэвтрүүлэх дэмжих мэдлэгжүүлэх зорилгоор сургалт зөвлөмж өгөх чиглэлээр ААН-г шинээр байгуулж хамтран ажиллаж байна
- Малын тэжээл тариалалт үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
- “Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж”-үүдийг шинээр байгуулж орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөс 8 аж ахуй нэгжийг 120.0 сая төгрөгөөр дэмжсэн байна.

**БУЛГАН:**

- “Булган-Зөгий” дэд хөтөлбөр, “Шинэ Хөдөө- Булган” дэд хөтөлбөрүүдийг батлуулж хэрэгжүүлсэн.
- “Булган Зөгий” хөтөлбөрүүдийн хүрээнд Булган суманд 30, Хангал суманд 35, Хялгант тосгонд 40, Сэлэнгэ суманд 30, Бугат суманд 25, Тэшиг суманд 30, Хутаг-Өндөр суманд 30, Баян-Агт суманд 30, нийт 250 зөгийн бүл, тоног төхөөрөмжийг 179.9 сая төгрөгөөр худалдан авч 43 өрхөд нийлүүлсэн.
- “Шинэ Хөдөө-Булган” дэд хөтөлбөрийн хүрээнд малын чанар үүлдэр угсааг сайжруулахад махны чиглэлийн “Сэлэнгэ” үүлдрийн үхрийн ашиг шим үүлдэрлэг байдлыг сайжруулахад Герефорд үүлдрийн бух 15, Сэлэнгэ үүлдрийн үхрийг үржүүлэх бүс нутагт Хангал, Бугат, Тэшиг, Хутаг-Өндөр сумдад Герефорд-Сэлэнгийн 1-р үеийн эрлийз бух 35, Баян-Агт, Сайхан, Могод, Гурванбулаг, Бүрэгхангай, Орхон, Дашинчилэн, Баяннуур, Рашаант, Хишиг-Өндөр сумдын үхрийн махан ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор 44-н толгой “Сэлэнгэ” үүлдрийн үхрийн өсвөр хээлтүүлэгчийг нийт 200.3 сая төгрөгөөр нийлүүлээд байна
- Сэлэнгэ сумын үржлийн аж ахуйн нэгж болох “Ингэт сүрэг” ХХК-нд Герефорд үүлдрийн 25 бухыг гэрээгээр эзэмшүүлэн “Сэлэнгэ” үүлдрийн үхрийн цөм сүрэгтэй малчин өрхүүдэд үржлийн сайжруулагчаар ашиглуулж байна.
- Бог малын чанар, хээлтэгч хээлтүүлэгчийн тохироог сайжруулах зорилгоор “Баяд” үүлдрийн хуц 300, “Цагаан уул” үүлдрийн хуц 120, “Эрчим хар” үүлдрийн ухна 50 толгойг 94.9 сая төгрөгөөр авч үржлийн аж ахуйн нэгж “Хужирын адаг” ХХК-нд гэрээгээр эзэмшүүлэн аймгийн урд бүсийн 8 –н сумын малчдад түрээсээр үржилд ашиглаж байна.
- “Шинэ Хөдөө-Булган” дэд хөтөлбөрийн хүрээнд малын зохиомол хээлтүүлгийн иж бүрэн багажийг 54.0 сая төгрөгөөр авч Хангал, Бугат, Тэшиг, Баян-Агт, Хишиг-Өндөр, Орхон, Могод, Гурванбулаг, Рашаант, Бүрэгхангай, Баяннуур, Дашинчилэн сумдад нийлүүлээд байна.
- Герефорд” үүлдрийн гүн хөлдөөсөн үрээр Булган суманд 45, Хутаг-Өндөр 30, Сэлэнгэ 35, Дашинчилэн 30, Гурванбулаг 20, толгой үнээ нийт 160 толгой үнээнд зохиомол хээлтүүлэг хийсэн байна.
- Өндөр ашиг шимтэй тахиа, гахай, мах-сүүний, махны үхэр үржүүлэх чиглэлээр 2019 онд Хангал суманд тахиа, гахайн аж ахуйг дэмжихэд 60.0 сая, махны үхэр үржүүлэхэд 50.0

сая, Орхон суманд гахай аж ахуй байгуулахад 40.0 сая, Хутаг-Өндөр суманд махны үхэр үржүүлэхэд 30.0 сая, Хишиг-Өндөр суманд махны үхэр үржүүлэхэд 22.0 сая төгрөгний дэмжлэгүүдийг жижиг дунд үйлдвэрийн сангаас олгосон байна.

• Сум хөгжүүлэх сангаас махны, мах-сүүний үхэр үржүүлэх чиглэлээр Булган суманд 2 төсөлд 20.0 сая, Бугат суманд 4 төсөлд 26.0 сая, Дашинчилэн суманд 8 төсөлд 58.0 сая төгрөгний зээлийн дэмжлэг үзүүлжээ.

#### БАЯН-ӨЛГИЙ:

- Дэд хөтөлбөр боловсруулсан.
- ЖДҮХСангаас шинээр фермер байгуулах Өлгий сумын 3 иргэний төсөл шалгарч 90.0 сая төгрөгний жилийн 5,6 хүүтэй 5 жилийн хугацаатай хөнгөлттэй зээл олгосон.
- Иргэдийн захиалгаар 50 үнээнд гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн.Хэл авалт 75%-тай байна. Мөн аймгийн төвд 6 бухаар 210 үнээнд гардан хээлтүүлэгт оруулжээ.

#### ГОВЬ-АЛТАЙ:

- 2019 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 4 аж ахуй нэгжид 173.2 сая төгрөг, сум хөгжүүлэх сангаас 3 иргэнд 21.2 сая төгрөгийн зээлийг олгосон.
- 135 малчныг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймагт туршлага солилцох аялалд хамруулсан.
- “Баянтооройн бүрд” ХХК-д тэжээлийн үйлдвэрийн чиглэлээр нийт 126,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн
- “Үржлийн шилмэл мал-2019” үзэсгэлэн дуудлага худалдааг Алтай хотод зохион байгуулсан байна.

#### ДАРХАН-УУЛ:

- Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан ИТХТ-ийн 2019 оны 28 дугаар тогтоолоор батлуулсан.
- “Туслах аж ахуйн хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулсан
- “Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай” Монгол улсын Засгын газрын 2018 оны 131 дүгээр тогтоолд тус аймгийн “Орхон, Хонгор” сумд тариалангийн бүс нутгаар тогтоосон. Бүс нутаг болгон тогтоосонтой холбогдуулан газар тариаланг эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна.
- “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Булган, Төв аймгуудыг хамруулсан төвийн бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулсан. Нийт 200 гаруй төлөөлөгчид хамрагдан Төрийн болон төрийн бус 11 байгууллага мэдээлэл хийж оролцсон.
- “Нарийн нарийвтар ноост хонь үржүүлэгчдийн Улсын зөвлөгөөн”-ийг зохион байгуулан 5 аймгийн хонь үржүүлэгчид хамрагдан тулгамдаж буй асуудлаа зөвлөлдсөн.
- Хонгор сумын Хар бэлчирийн аманы 5 га газарт 236,2 сая төгрөгийн хөрөнгөөр дэд бүтэц татах, өвөлжөө, худаг ус, эмчилгээ - үржлийн ажил үйлчилгээний цэгийг байгуулав.
- Орон нутгийн төсвийн 150 сая төгрөгөөр Сэлэнгэ үүлдрийн 100 толгой гунж, 3 толгой бухыг нийлүүлж махны чиглэлийн үхрийн цөм сүргийн аж ахуйг байгуулаад байна.
- “Хатан зөгий” холбоотой хамтран ажиллаж нийт 180 гаруй зөгийчдөд 9 удаагийн сургалт, талбайн өдөрлөг, зөвлөгөөнийг зохион байгуулсан.

- Аймгийн 2019 оны Алтан намар үзэсгэлэн худалдаанд 17 зөгийчид зөгийн балаар оролцож Орхон сумын зөгийчин “Эко бүтээгдэхүүний шагнал” авсан байна.

- Аймгийн Хөдөлмөр, Халамж Үйлчилгээний газартай хамтран ОХУ-ын Эрхүү мужийн Белореченскийн сүүний хар тарлан үхрийн ферм, Улаан-Үд, Хиагт орчмын фермерүүдтэй танилцах аялал зохион байгуулан 100 гаруй малчид, фермерүүд хамрагдаад байна.

- Мөн ӨМӨЗО-ны Хөх хот болон 3 аймгийн сүү, махны фермерүүд болон сүүний үйлдвэр, тэжээлийн ургамал тариалалтын чиглэлээр туршлага судлах аялалыг зохион байгуулан 150 гаруй малчид, фермерүүд оролцсон байна.

#### ДОРНОГОВЬ:

- Өргөн сумын “Зээгийн хөтөл ”-ийн 40 га газрыг газар тариалан, мал маллагааны бүс нутаг болгон тогтоосон.

- Үхрийн 1, гахайны 2, шувууны 1 нийт 4 аж ахуйг төрөлжүүлэн баталгаажуулсан.

- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн зүүн бүсийн сургалт зөвлөгөөнд 10 сумын 15 эрчимжсэн аж ахуй эрхлэгч хамрагдсан.

- “Сэнж сант” ХХК нь бог малд үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх, анги чанарыг тогтоох, бүртгэл хөтлөх зэрэг ажлыг гүйцэтгэж байна.

- Сайншанд сумын 1 иргэн өөрийн хөрөнгөөр 5000 тахиа худалдан авч үйл ажиллагаагаа эхлүүлж байна.

- **800-н үхэрт** үүнээс хээлтүүлэгч **18**, хээлтэгч **782** толгой үхэрт төлөв байдлын үнэлгээ хийгдсэн байна.

- Сайншанд сумын 3 иргэн, аж ахуй нэгж эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулсан эрхэлж байна.

- 6 суманд 9 малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэгдэн үйл ажиллагаагаа явуулж байна.

- Мах, сүүний чиглэлийн Алатау, Хар тарлан, Үзэмчин, Барга үүлдрийн шингэлсэн үрээр болон гардан хээлтүүлгийг нийт **135** толгой бод, **487** бог малд хийж төлөвлөгөөний биелэлт **88.6** хувьтай байна.

- ЖДҮ-сангаас 2 аж ахуйн нэгжид **104** сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон.

#### ДОРНОД:

- Улсын төсвийн 12,8 сая төгрөгийн хөрөнгөөр Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлыг “Үет цагааны гол” ХХК-тай гэрээ байгуулан 6 сумын 115 малчин өрхийн тэмээ 300 толгой, адуу 2790 толгой, үхэр 2430 толгой, хонь 11240 толгой, ямаа 7020 толгой нийт 23780 толгой малыг хамруулан зохион байгуулж ажиллаа.

- ЖДҮ эрхлэгчдэд олгож буй хөнгөлттэй зээлд Хэрлэн, Матад сумдын 4 иргэн, аж ахуйн нэгжид фермерийн үйл ажиллагаа, мал бордох, тэжээх болон мах-сүүний чиглэлийн үхэр өсгөн үржүүлэх чиглэлээр 100,0 сая төгрөгийн хөнгөлттэй зээлэнд хамруулж дэмжлэг үзүүлсэн.

- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 5 сумын 6 иргэн, аж ахуйн нэгжид 65,0 сая төгрөгийн зээлийг олгосон. Аймгийн хэмжээнд нийт 7 сумын 10 иргэн, аж ахуйн нэгжид 165,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.

- Дорнод талын махны хэвшлийн 25 үнээнд ангус үүлдрийн бухны гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийж гүйцэтгэсэн.

- “Мал үржлийн ажлын хөтөлбөр” батлуулж, үржлийн хөтөлбөрийн хүрээнд Дашбалбар сумын Харзат багт Буриад омгийн хонины хээлтүүлэгчийн нэг суурь бий болгож 100 толгой хээлтүүлэгчийг төвлөрүүлээд байна.

- Аймгийн хэмжээнд 21 үүлдэр, омог, хэвшлийн болон эрлийз нутгийн, шилмэл омгийн мал 317263 толгой мал тоологдсон нь нийт малын 12.0 хувийг эзлэж өмнөх онтой харьцуулахад 17740 толгой буюу 5.9 хувиар өссөн дүнтэй байна.

- махны чиглэлийн Казакийн цагаан толгойт 5105 толгой буюу нийт үхрийн 1,8 хувийг эзлэж, үүнээс Баян-Уул суманд махны чиглэлийн Казакийн цагаан толгойт үүлдрийн үхэр 4609 толгой буюу нийт Казакийн цагаан толгойт үхрийн 90,2 хувийг өсгөн үржүүлж байна.

- махны чиглэлийн Дорнод Монголын улаан үүлдрийн үхэр 5696 толгой буюу нийт үхрийн 2,0 хувь, үүнээс Халхгол суманд Дорнод Монголын улаан үүлдрийн үхэр 5002 толгой буюу 87,8 хувийг өсгөн үржүүлж байна.

- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн зүүн бүсийн сургалт, зөвлөгөөн-2019" 05 дугаар сарын 24-ны өдөр Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн хурлын танхимд зохион байгуулж, зөвлөгөөнд Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь, аймгуудын эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид 100 хүн оролцсон.

#### СҮХБААТАР:

- Дорнод аймагт зохион байгуулсан зүүн бүсийн Эрчимжсэн МАА эрхлэгчдийн бүсийн сургалт, зөвлөгөөнд газар тариалан, сүү, махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчид, мал үржлийн мэргэжилтнүүдийн 17 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.

ЖДҮХ сангийн зээлд 4 иргэн, аж ахуйн нэгжийн 400 гаруй сая төгрөгийн төсөл дэмжигдсэн. ҮТП-аас 1 иргэнд Гахайн аж ахуй эрхлэхэд 100.0 сая төгрөгийн зээл олгосон.

- “Хүнсний аюулгүй байдал, сүү цагаан идээ боловсруулах технологи” сургалтыг аймгийн төвд 7 сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулж 13 сумын 41 иргэн хамрагдаж сүүн хурууд хийх арга технологи эзэмшсэн. Сургалтанд хамрагдсан иргэд “Сүхбаатар хөгжил -2019” зах зээлийн өдөрлөгт оролцож 200 гаруй кг хэвийн ааруул идээ зарж борлуулсан.

- Дарьганга, Баяндэлгэр, Халзан, Мөнххаан, Эрдэнэцагаан сумдад 25-50 үнээтэй тасаг байгуулж төсвийн байгууллагын ажилчид, зорилтот бүлгийн иргэдийг ажиллуульж амжилттай зохион байгуулсан.

- Сүүний үнээний эрчимжсэн ферм, малчдыг дэмжих зорилгоор 61,1 сая төгрөгийн өртөг бүхий 14 нэр төрлийн 258 ширхэг тоног төхөөрөмж /айл өрхөд олгох 10 төрлийн 180 ш, хоршоонд олгох 10 төрлийн 78 ш/ -ийг Баруун-Урт, Дарьганга, Сүхбаатар сумдад олгосон.

#### ХӨВСГӨЛ:

- Фермерийн аж ахуй эрхэлдэг өрхүүд ногооны хаягдалаар 100 тонн дарш бэлтгэсэн.

- Зөгийн аж ахуй эрхлэгчдийн 3-р зөвлөгөөн 2019 оны 3-р сарын 19-ний өдөр зохион байгуулагдаж 80 хүн оролцсон.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд төслийг хэрэгжүүлэн ажиллаж төсөлд хамрагдсан иргэн тус бүрд 4, 800,000 төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаанд хүүгүйгээр эргэн төлөгдөх нөхцлөөр олголоо.

- Төсөлд хамрагдсан Хөвсгөл аймгийн Рашаант, Их-Уул, Тосонцэнгэл, Мөрөн сумдын нийт 40 иргэнд 2019 оны 7 сарын 22-нд Казахстан улсаас 430 бүл зөгийг зөгийн үүр хайрцаг, багаж хэрэгслийн хамт импортлон оруулж ирж олгов. Төсөлд хамрагдсан зөгийчид маань

энэ жил анхны балаа хураан авсан ба нийтдээ 2070 кг орчим бал хураан авч борлуулалт хийв.

- Бүрэнтогтох сумын Туяа багт Нэмүү өртөгийн сүлжээ төсөлөөс 2 тонны сүүний хөргүүр тавиж Титаник ХХК хүлээлгэн өглөө. Малчид, сүүний үхрийн фермерийн аж ахуй эрхэлдэг 5 хүнд 40 летрийн петон хүлээлгэн өгч үйл ажиллагааг дэмжсэн.

ТӨВ:

- Аймгийн ИТХТэргүүлэгдийн 2019 оны 82 тоот тогтоолоор “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих аймгийн төлөвлөгөө”

- Тариалангийн бүс нутгаар:

- Аргалант
- Архуст
- Батсүмбэр
- Баянхангай
- Баянцогт
- Баянчандмань
- Борнуур
- Жаргалант
- Заамар
- Сүмбэр
- Угтаалцайдам
- Цээл

- Эрдэнэсант сумын 1,2,3,4 дүгээр багуудыг тус тус тогтоосон.

- Архуст сумын “Хишигтэн Нүүдэлчин ХХК”-ийн үхрийн фермд эрүүл ахуйн шинжилгээ хийгдэж тус фермийн сүрэг эрүүл гэсэн онш гарч “Эрүүл сүрэгтэн” хэмээх гэрчилгээ авсан.

- Төв аймгийн Зуунмод хотод “Шилмэл мал 2019” улсын үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан.

- Баяндэлгэр сумын “Нүүдэлчин Агро Ферм ХХК” нь энэ онд сүү-махны хосолмол ашиг шимт Монбиллиард үүлдрийн 96 гунжийг Францаас оруулж ирж үйл ажилгааны цар хүрээгээ тэлсэн

- Цахилгаан саалтуур, зориулалтын сүүний бидон, Эрдэнэ сумын сүү боловсруулах цехэд хөргөлтийн танкийг хөнгөлттэй эргэн төлөгдөх зээлийн нөхцлөөр олгосон.

- 300 эр хургыг “Цахилгааны соронзон долгионы” багаж ашиглан төөнөж таслах аргаар хөнгөлж, махны гарц ашиг шимийг нэмэгдүүлж зах зээлд нийлүүлсэн.

- Нийт 1748 үнээнд зохиомол хээлтүүлэг хийгдсэн.

- Боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний аюулгүй байдлыг бүртгэлээр баталгаажуулах зорилгоор Төв аймгийн Эрдэнэ сумын Эрдэнэ Хүнс, Баяндэлгэр сумын Баяндэлгэр Хүнс зэрэг мах боловсруулах үйлдвэрүүдэд Антибиотикийн үлдэгдэл шалгадаг тестийн багаж төхөөрөмжийг ашиглаж эхэлсэн.

- 2019 онд Сум хөгжүүлэх сангаас нийт 56 аж ахуй нэгж иргэн 375,800,000 төгрөг, 1 иргэн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 46 сая төгрөгийн эрчимжсэн мал аж ахуйд чиглэгдсэн хөнгөлттэй зээлд тус тус хамрагдсан.

- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд зориулж тугалын маллагаа, тэжээллэг сэдэвт гарын авлага гаргасан. Сүүний болон махны үхэр, гахай, шувуу, зөгийн аж ахуй эрхлэгчдэд

малын нөхөн үржихүй, сүргийн бүтцийн зохистой харьцаа, арчилгаа, маллагаа, тэжээллэгийн мэдлэг олгох 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

#### УЛААНБААТАР:

- Багануур дүүргийн ЗДТГ-тай хамтран “Малчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, 350 гаруй малчдад холбогдох чиглэлээр мэдээлэл өгч мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.

- Нийслэл орчимд эрчимжсэн аж ахуйг цогц байдлаар хөгжүүлэх чиглэлээр сууршлын 3 бүсийг шинээр бий болгож, мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал гаргах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, иргэдийг суурьшуулахад шаардлагатай дэд бүтэц, цахилгаан, худаг усыг шийдвэрлүүлэн 2019 онд мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсийг шинээр нэмж тэлэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 21/06 дугаар тогтоолоор батлуулан нийт 232 өрхийн 6097 малыг зөвшөөрсөн бүс рүү нүүлгэхээс жилийн эцсийн байдлаар 202 өрхийн 5098 малыг зөвшөөрсөн бүсэд шилжүүлсэн.

- Нийслэлд эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, ферм эрхлэгчдийг чадвахжуулах чиглэлээр 2019 онд 13 төрлийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөөг батлуулан 6 дүүргийн ЗДТГ-тай хамтран “Залуу фермер”, “Мал аж ахуйн хоршоо”, “Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн зөвлөлдөх уулзалт”, “Ферм-аялал” сургалтуудыг тусгай хөтөлбөрөөр зохион байгуулж, 450 малчин, фермер эрхлэгчийг хамруулан мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.

- ХХААХҮЯ-ны Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаар дамжуулан олгосон төсөлд 2019 онд Нийслэлээс 3 иргэн, 1 аж ахуй нэгж журмын дагуу шалгуур үзүүлэлтийг ханган 893 сая төгрөгийн хөнгөлттэй зээлийн дэмжлэг авсан.

- “Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйд тавих ерөнхий шаардлага ”MNS6723:2018 үндэсний стандартыг нийтэд хүргэх, сурталчлах ажлыг зохион байгуулж, 6 дүүргийн мэргэжлийн холбоод, төр, хувийн хэвшил, ферм эрхлэгч 300 гаруй иргэдийг хамруулж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.

- Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд мал бүхий 6 дүүрэгт Хөдөө аж ахуйн тасгийг шинээр байгуулахаар холбогдох шийдвэрийг гаргуулан ажилласан.

- “Шилмэл мал-2019” гойд ашиг шимт үржлийн мал, амьтан шалгаруулах үзэсгэлэн худалдааг ХХААХҮЯ-тай хамтран Төв аймагт 09 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгуулж Нийслэлийн 3 дүүргийн 12 иргэн, 1 аж ахуй нэгжийн 30 мал, амьтадыг оролцуулж, сүүний чиглэлийн шилмэл хээлтэгч, хээлтүүлэгчийн тэргүүн, дэд байранд Нийслэлээс шалгарч, хот орчмын эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг нийтэд сурталчилж ажилласан.

- Шинэ технологи, инноваци нэвтрүүлэх чиглэлээр СХД-ийн 32 дугаар хороонд тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр “Протейн” тэжээлийн үйлдвэр 2019 онд байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлсэн

- “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХХААХҮЯ, МСНХ-той хамтран “Сүүний аж ахуй эрхлэгчид, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн чуулган”-ыг 2019 оны 12 дугаар сарын 17-нд зохион байгуулж, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1299 дүгээр захирамжаар дэмжлэг үзүүлэх санхүүжилтийг шийдвэрлүүлэн Нийслэлийн 6 дүүргийн 350 фермийн аж ахуй эрхлэгчдийг оролцуулан, хэвлэл мэдээллээр нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.